

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс**

2022 он

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц
1	1	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасгай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж,	Тус хэлтсийн гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр бичсэн. УБЕГазрын вэт сайт тавигдсан монгол бичгийн 40 хичээлийг бүх албан хаагчид бие даан үзэж дуусгасан байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 5 зураг

			хэвшүүлэх.	
2			<p>XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг Засгийн газрын гишүүд, бүх шатны төрийн захиргааны болон нутгийн захиргааны</p>	<p>Хэлтсийн угтах үйлчилгээний ажилтан цахим үйлчилгээг хариуцан ажиллаж байгаа бөгөөд E-Mongolia, Opendata-аар дамжуулан иргэний улсын бүртгэлийн чиглээр 80, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 102, гэрхийн бүртгэлийн чиглэлээр 102, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 70, бусад төрлийн бүртгэлийн чиглэлээр 61, нийт 320 иргэнд лавлагаа олгож ажиллалаа. Мөн угтах үйлчилгээний ажилтан нь иргэдэд бүртгэлийн үйлчилгээг ойртуулахад шаардлагатай мэдээ мэдээллийг хүргэх, бүрдүүлэх материалын жагсаалт болон иргэдэд бүртгэлийн зөвлөмж, чиглүүлэх үйлчилгээг үзүүлж, давхар албан хаагчдын цаг бүртгэлийг хянаж гадуур ажлын дэвтэр хөтлөх зэрэг ажлуудыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна.</p> <p>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн</p> <p>Хавсралт : 2 зураг</p>
2	2022 оны дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	2 шатны байгууллагад даалгав.		

3	3	<p>2022 оны 5XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн дугаар сарын 11-хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалант 2022-05-11 Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалант, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт төрийн болон орон нутгийн өмчит этгээдийн удирдлагад үүрэг болгов.</p>	<p>2022 оны 5 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн нэг томоохон ажил болох тоон гарыг үсгийг олгох ажлыг аймаг орон нутагтаа зохион байгуулан ажиллаж байна. УБЕГ-аас 2022 оны 4 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулсан тоон гарын үсэг олгох сургагч багш бэлтгэх сургалтанд иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Х.Наранчимэг хамрагдаж, сумдын улсын бүртгэгч нарт тоон гарын үсэг олгох сургалтыг 4 дүгээр сарын 28-нд онлайн хэлбэрээр эрх зүйн болон программын сургалт гэсэн 2 төрлөөр зохион байгууллаа. Тоон гарын үсгийн олголтыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд явуулын сүлжээтэй болох талаар УБЕГ-т хүсэлт тавьж, юнителийн 4G сүлжээтэй болсоноор аймгийн хэмжээнд олгогдож байгаа тоон гарын үсгийн явц болон иргэдийн хамрагдалт өссөөр байна. Мөн аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудаар өдөр</p>
---	---	---	--

				<p>өдрөөр хувиар гарган албан хаагчдыг бүрэн хамруулах талаар байгууллагын удирдлагуудтай урьдчилан ярьж төлөвлөгөө гарган дараах байгууллагын албан хаагчдыг хамрууллаа. Үүнд : Аймгийн нэгдсэн эмнэлэгийн 150, Зэвсэгт хүчний 338-р ангийн 130, Ус дулааны Дөрвөлж ОНӨҮГ-ын 100, Цайрт минерал ХХК-ны 200 гаруй, аймгийн Засаг даргын тамгын газрын 50, Ерөнхий боловсролын 1,2,3,4 дүгээр бүрэн дунд сургуулийн 300 орчим багш ажилчин албан хаагчдад, аймгийн хөгжимт жүжгийн Жаахан шарга, ХААН, Хас, Голомт банкны 100 орчим ажилчин албан хаагчдад тус тус тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдолын талаар бүх ажилчдын хурал дээр мэдээлэл танилцуулга хийж, тоон гарын үсэг олгож ажиллалаа. Аймгийн хэмжээнд 16 ба түүнээс дээш насны 43000 иргэн байгааг жилийн эцсийн байдлаар 4910 иргэнд буюу нийт иргэдийн 11.4 хувь нь хамрагдаад байна.</p>
--	--	--	--	--